



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐᠒5 оны ᠕ сарын ᠕ өдөр

Дугаар А/᠑33

Улаанбаатар хот

### Нийслэлийн хүүхдийн 284 дүгээр цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.7 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалаар байгуулагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 8 нэр төрлийн нийт 7,203,857.32 (долоон сая хоёр зуун гурван мянга найман зуун тавин долоон төгрөг гучин хоёр мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн хүүхдийн 284 дүгээр цэцэрлэг (Н.Баярмаа)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 8 нэр төрлийн татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн нийт 7,203,857.32 (долоон сая хоёр зуун гурван мянга найман зуун тавин долоон төгрөг гучин хоёр мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөхийг Нийслэлийн хүүхдийн 284 дүгээр цэцэрлэг (Н.Баярмаа)-т, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *В.Оюунмаа* В.ОЮУМАА





